



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 262

Улаанбаатар хот

Барилгын тусгай зөвшөөрлийг шинээр олгох,
нэмэлт ажлын төрлөөр олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6, 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь заалт Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 147 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 21/763/ТЗ тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг нэгдүгээр, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг нэмэлт ажлын төрлөөр олгох байгууллагын жагсаалт”-ыг хоёрдугаар, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг сунгах аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ /Д.Цэрэнжигмэд/-д тус тус даалгасугай.



Б.МӨНХБААТАР


151010813

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
262 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ АЖ
АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Хан алтач холдинг" ХХК	Барилга угсралт, шинэ БА-6.3, 6.4	5

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
262 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ НЭМЭЛТ АЖЛЫН ТӨРЛӨӨР
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Өгөөмөрөн шанд" ХХК	Барилга угсралт, нэмэлт БА-3.3	-

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
262 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ АЖ АХУЙН
НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Барилгын ажлын төрөл	Хугацаа
1	"Нэксст стандарт" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-2.1, 3.3, 3.4, 6.1, 6.2, 6.3, 7.1	5
2	"Топ-инсайт" ХХК	Барилга угсралт, сунгалт БА-6.3, 6.4	5
3	"Дашваанжил" ХХК	Зураг төсөл, сунгалт ЗТ-3.6, 8.1	5